ХУРГАТАЙ ХАЙРХАН

Ярилцлагын булан



“Нутагтаа ажиллана гэдэг надад хамгийн чухал”

-Б.Анхбаяр

ХУРГАТАЙ ХАЙРХАН



“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, тогтвортой орлоготой болгохыг зорин ажиллаж байна. Энэ удаад бид төслийн кемпэд тогоочоор ажиллаж буй орон нутгийн ажилтныг онцолж, түүний ажлын туршлага, сэтгэгдэл болон нутагтаа ажиллахын үнэ цэнийг хуваалцаж байна.

Та өмнө нь хаана, ямар чиглэлээр ажиллаж байсан бэ?

Би өмнө нь “Могойн гол” ХК-ийн уурхайд тогоочоор ажиллаж байсан. Тэнд ажиллах хугацаандаа уурхайн нөхцөлд олон хүний хоол үйлдвэрлэлийг зохион байгуулах, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх, цаг хугацаанд нь хоол бэлтгэх зэрэг тал дээр туршлага хуримтлуулсан. Ийм төрлийн орчинд ажиллахад зохион байгуулалт, хариуцлага чухал байдгийг ойлгосон.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Овоот” төслийн багт нэгдсэн сэтгэгдэл ямар байна вэ?

“Овоот” төслийн багийн нэг хэсэг байгаадаа их баяртай байдаг. Ажлын орчин, зохион байгуулалт сайн санагдсан. Ялангуяа орон нутгийн иргэдийг ажилд авч байгаа нь бодит боломж болж байгааг анзаарсан. Миний хувьд өөрийн нутагтаа ажиллаж, тогтвортой орлоготой байх боломж бүрдэж байгаад сэтгэл хангалуун байна.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Кемпийн тогоочийн ажил юугаараа онцлог вэ?

Кемпийн тогоочийн ажил нь олон хүний хоолыг богино хугацаанд, чанартай бэлтгэх шаардлагатай байдаг онцлогтой. Мөн ажилчдын эрүүл мэнд, тэнцвэртэй хооллолтыг хангах нь чухал. Уурхайн орчинд ажиллаж байгаа хүмүүсийн ачаалал өндөр байдаг учраас хоол хүнс нь тэдний өдөр тутмын эрч хүчид шууд нөлөөлдөг гэж боддог.



ХУРГАТАЙ ХАЙРХАН



Цаашид ажилдаа ямар зорилго тавин ажиллахаар төлөвлөж байна вэ?

Цаашид ажилдаа илүү туршлага хуримтлуулж, хоол үйлдвэрлэлийн чанарыг тогтвортой сайн түвшинд барихыг зорьж байна. Мөн хамт олонтойгоо ойлголцож, ажлаа чанартай гүйцэтгэх нь миний хувьд чухал. Урт хугацаанд орон нутагтаа тогтвортой ажиллахыг хүсэж байна.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Байгальд ээлтэй
Орон нутагт өгөөжтэй



Зураг. Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 2024 он
“Хургатай Хайрхан” ХХК-ийн хэрэгжүүлдэг “Малын ногоон тэжээл” хөтөлбөрийн тариалангийн талбай